

**ЖАЛ-ЗЭЭ-ТЭМ-БАН
БУЮУ НҮХЭТ БИЧМЭЛ
ГАНЖУУРЫН ТУХАЙ**

Н. Дашзэвэг

Манай монгол эх орны соёлын их сан хөмрөгт Төвдийн Дэргээ, Нартан, Лхас, Жонь, Энх-Амгалан хааны чулуун ба зэс барын, Халхын их хүрээний барын Ганжуур-Данжуур, мөн дан Алт ба есөн эрдэнэ, хар бэх, улаан шунхаар бичиж бүтээсэн арваад нэр төрлийн Ганжуур-Данжуур хэмээх их хөлгөн судрууд байдаг. Эдгээрийн дотроос манай Улсын нийтийн номын санд хадгалагдаж байгаа 110 боть Жал-Зээ-тэм-бан буюу «нүхэт» хэмээх гар бичмэл Ганжуурын талаар гадаад оронд болон манай оронд шинжлэн судалж бичиж нийтлүүлсэн зүйл сүүлийн үед гарч буй гэх боловч сонирхогч ихэнх хүмүүс учир утгыг ялган салгаж мэдэхгүй тал их байдаг билээ. Иймд энэ Ганжуурын талаар судлан мэдэх явдал эртний ном соёлын судалгаанд их ач холбогдолтойгоор барахгүй Энэтхэг, Төвд, Монголын соёлын харилцааны түүхийг судлахад чухал суурийг эзэлнэ. Энэ нэрийг орчуулбал «Rgyal» нь хаан «tze» нь тэргүүн буюу орой, «them»-нь босго тэвчих буюу нэг үгээр хэлбэл «Хааны оройн чимэг, тэргүүн шүтээн, босгоор ч гаргаж үл болох нандин судар шүтээн» гэсэн утгатай төвд үг юм.

Уг нь энэ Ганжуурыг Төвдийн нэгэн хаан Жал-зээ Содномравдан удирдан их эрдэмтэн Бүдон-Ринчиндүвээр бичүүлж гурав дахин шүүлэгсэн гэдэг бөгөөд түүний талаар сонин домог байдгийг өгүүлбээс: Эрт цагт Төвдийн нэгэн томхон угсаатан өөрийгөө залгамжлах сайн хүүтэй болохыг хүсч байтал удалгүй хатнаас нь нэг хүү мэндэлжээ. Гэтэл тэр хүү нь толгой нь маш том (макроцефали), ам нь чихэндээ хүрсэн сармагчин шиг нүүртэй хүүхэд гарсанд ноён уурлаж устгах арга сүвэгчлэхэд нь эх нь үрээ хайрлахын эрхэнд нэг сайн зөнч бэлэгчид үзүүлсэнд энэ хүүг үгүй хийж болохгүй, гайхамшигт их эрдэмтний шинж бүрдсэнээр барахгүй ер мянган сайн хүүгийн шинж хадгалсан ер бусын хүү байна. Ийм учир энэ хүүд би Бүдон-Ринчиндүв гэдэг нэр өгье, асран хүмүүжүүлж 3 настайгаас нь эрдэм ном зааж өг гэжээ¹.

Тэр хүүг, эцэг эх нь бусдаас нууцлан эрдэм ном заалгаж, хүү ч олон янзын эрдэм ухааныг төдөлгүй суралцсаны дотор сайн бичээчээр барахгүй зохиох, орчуулах эрдэмд гарамгай болж эрдмийн зэрэг цол хүртжээ.²

Энэхүү алдарт эрдэмтэн Тамчид-чинва-Бүдон-Ринчиндүв нь V жарны цагаан бар жил буюу 1290 онд төрж VI жарны хөх луу жил буюу 1364 онд 75 насандаа таалал төгсжээ.

Тэрээр эртний Энэтхэг төвдийн их бага таван ухааны 30 боть ном зохион бичсэний дотор Бүдон-Чойжун гэдэг бурхны шашны түүхийн ном зохиосныг хожим эрдэмтэн Е. Обер-миллер англиар орчуулж 1931 онд хэвлүүлжээ.

«Жал-зээ-тэм-бан» Ганжуурыг Бүдон-Ринчиндүв маш идэвхилэн мутараар бичиж гурав дахин өөрөө алдаа мэдгийг шүүж бүтээсэн гэх бөгөөд үүнийг манайхан «нүхэт» Ганжуур гэж нийтэд нэрлэж иржээ. «Нүхэт» гэсэн учир бол уул номын хуудас бүрийн хоёр үзүүр хирд 10 мм нүх гаргах дугуй тэг татсанаас болж «нүхэт» Ганжуур хэмээн нэрлэсэн ба уг нь эрт цагт Энэтхэг-Төвдөд номыг тэгж нүх

гаргаж тэр нүхээр нь хадгаар оосорлон бэхлэж уядаг байсан учир номыг холихгүй бэх бат сайн арга гэж үздэг заншилтай нэгэн үе байжээ. Энэ Ганжуур бол нэг боть нь 500-800 орчим хуудастай дотроо 1260-аад эхт зохиол сэдэв багтсан, ер нь нэг хүн бичсэн гэхэд үнэмшмээргүй боловч үүний бичгийн тэг хэлбэр аргагүй л нэг хүний бичиг мөн бололтой гэж үсэг судлаачид үздэг байна.

Тэгээд энэ алдарт гар бичмэл Ганжуураа бичиж төгсөөд төвдийн номын хаан Ванчин Содном-равданд барьжээ. Тэр хаан энэ Ганжуурыг хүлээж аваад боть судар нэг бүрт Алтан мөнгөн есөн эрдэнэ алаглуулан шигтгэсэн зузаан мөнгөн хавтас хийлгэж, энэ Ганжуураа «Жал-зээ-тэм-бан» хэмээн нэрлэж хүндэт нандин шүтээн болгон Лхасын улаан ордонд нандигнан залж «Босго алхуулж болохгүй». Хэрэв зөрчвөл тэргүүнийг авч «цаазлана» хэмээн хатуу зарлиг гаргажээ.³ Тэгээд энэ судрыг нэгдүгээр Ванчин богд Лувсанчойжалцан (1570--- 1662) тавдугаар Далай Лам Агваанлуvsсанжамц (1617—1682) хоёр хэлэлцэж өөрийн дотно шавь Халхын Өндөр гэгээн Лувсандамбийжалцан (1635--1723) Лхаст очиж мөргөх үед нь нарийн урлалтай олон нандин бурхадын хамт уг Ганжуурыг бэлэглэхээр шийджээ. Тэр үед Лхасын номын сангийн ганжуурыг хариуцсан хүмүүс нь нэгд хааны хатуу зарлиг, хоёрт үнэт нандин судрыг гадаад гүрэнд өглөө гэж битүүдээ баахан дургүй байсан боловч нэлээд түдгэлзэж байгаад хоёрдугаар Ванчин Лувсан-Ишийн (1663— 1737) үед буюу 1671 онд Халхад явуулах болж дургүйцэж байсан төвд лам нар алт шармал есөн эрдэнэ шигтгэсэн зузаан хүнд мөнгөн хавтасыг мултлан авч зөвхөн эхний боть «Жадамба» (найман мянган шүлэгт) судрыг нь, хэвээр, бусад 110 ботийг нь хамба торгон баримтагтай нь явуулжээ. Монголчууд тэр ганжуурыг Лхасаас залж авчраад ганцхан эхний боть «Жадамба», «Додигалсан» (мянган бурханы судар») хоёрыг Их хүрээний гол нандин шүтээн Очир-дар бурханы дэргэд залж, бусад ботиудыг нь Хүрээ Их цогчин буюу Бат цагаан хэмээх дуганд залж үргэлж уншсаар байжээ. Тэгээд Өндөр гэгээнээс аваад удаа дараагийн Богдууд их л хайрлан хамгаалж байсны дотор дөрөвдүгээр Богд Лувсантүвдэнванчиг Чингэлтэй ууланд байгуулсан Гипэл-Жанчивлив буюу Шадүвлин хийддээ авчирч үзэж байсан гэдэг. Энэ Богдоос хойш Туул голын доод Цагаан (үйлдвэрийн комбинатын баруун талд байсан) сүмд хэсэг байсныг Тавдугаар Богд Лувсанчүлтэмжигмэд 1835 онд байгуулсан Гандантэгчлэн хийдэд залсан учир жил бүр хуруулж мөргөлчин, сүсэгтэн хүмүүс 3—4 ботийг тусгай үүргэвчтэй үүрч хүрээ Ганданг дан буюу давхар эргэдэг байв. Тэр идэвх зүтгэлтэй эргэгчдийн нэг нь миний эцэг эх хоёр байлаа. Би бага балчир хүүхэд дагаад явдаг байв. Тэр цагт энэ Ганжуурыг үүрээд эргэх нь Их хүрээний хүндтэй том ажлын нэг гэж үздэг байсан юм.

Ганжуурыг үүрээд Ганданг тойргоор нь, Их хүрээг тойргоор нь, эргэж явахыг дан эргэх гэнэ. Гандан Хүрээ хоёрыг хамт тойргоор нь эргэхийг давхар эргэх гэнэ. Мөн Голын цагаан сүмийг дангаар 108 удаа эргэх гэж бас байдаг байсан бөгөөд хувьсгалаас өмнөх хүмүүс өдөр сарыг шашин бурханы эргэл мөргөлөөр ингэж л өнгөрөөдөг үе байлаа. Миний эцэг Нанзад (өндөр) хүрээ Ганданг олон удаа эргэсэн учир их чадал тэнхээтэй Буянтай хүн гэгддэг байсан юм. Энэ Ганжуурын 4-6 ботийг давхарлан үүрдэг, одоо бодвол 70—80 кг орчим хүнд юм. Энэ завсар нэг сонинг дурдахад Даригангын хорооны нэг ганган эр Алтан шүдэт (нэр мартжээ) гэдэг хүн эхнэрийнхээ хамт нөгөө Ганжуурыг морин тэргэнд ачиж Хүрээ Ганданг эргэсэн учир хүмүүс үзээд бөөн шуугиан болж, тэднийг шоолж инээлдэж байжээ. Энэ «нүхэт» Ганжуурыг миний ид өсөх үед одоогийн Гандантэгчлэн

гийн хийдэд хадгалж байсан бөгөөд зун цагийн их Хайлин гэдэг тусгай дэглэмт 45 хоногийн хурлаар жилд нэг удаа үсэгчлэн уншиж Дашчойнпил дацанд хурдаг байсан учир тэр үеийн нэг зиндааны багачууд бид даах хирээр авчирч уншуулаад Гандантэгчлэнд буцааж байрлуулдаг байв. Ингээд энэ Ганжуурыг балчир багадаа эцэг, эхээ дагаад Хүрээ, Гандан, Голын цагаан сүмийг дан давхар тойрч, өсөх насандаа Гандантэгчлэн хийд Дашчойнпил дацан хоёрын хооронд үүрч зөөж байгаад бүр сүүлд 1980 онд УНН-ын санд ахлах номын санч, төвд хэлний орчуулагч, эрдэм шинжилгээний ажилтан гэдэг сайхан алдрыг хүлээж байх үедээ «нүхэт» Ганжуурын 110 ботийг ядаж олон жилийн тоос шороог арилгаж бас чадвал нэг удаа уншиж хэрэгтэй зүйлийг тэмдэглэж авах санаатай судрын аймгаас эхнээс хэдэн боть уншаад, бас цааш нь боть бүрт тодорхой нэгэн ижил хаяг (дондар) хийж эхэлсэн боловч орон тооны илүүдэл гэдгээр ажлаас гарч одсон билээ. Эртний соёлын түүх дурсгалаар баян, Энэтхэг төвдийн их бага арван ухааны эрдмийн цоморлог Дорнодахины соёлын харьцааны нэгэн хэрэглүүр болох «Жал-зээ-тэм-бан» буюу «нүхэт» хэмээх бичмэл Ганжуурын эрт эдүгээгийн түүх намтрыг өгүүлэхэд ийм ажээ.

Одоо энэ судар УННС-ийн алтан фондод нандигнан хадгалагдаж орчин цагийн залуу эрдэмтдийн судалгааны ном болоход бэлэн байна.

¹Ганжуурын лүнгийн жүдрэм сэнвэрээ нацаг. (Ганжуур уншсан лам нарын үндэс дарааллын тэмдэглэл элдэв зүйл)

²Зая бадидаа Лувсанпэрэнлэйн (са-ег) номын 3-р боть

³Нанзаддорж агримбийн зохиол Данзэ-нацаг (шашны түүхийн элдэв тэмдэглэл)

**«ДЭНБЭРЭЛДОДВА
RTEN-'BREL-BSTOD-PA»
ХЭМЭЭХ ЗОХИОЛЫН
МОНГОЛ ОРЧУУЛГА
ТАЙЛБАРЫН АСУУДАЛД**

Р. Бямба

XIV зууны үеийн төвдийн гүн ухаантан Зонхава (1357-1419)-гийн магтаалын¹ зохиолоос Монгол, Төвдөд үлэмж алдаршиж эрдэмтдийн анхаарлыг татсан зохиол бол «Дэнбэрэлдодва» буюу «Шүтэн барилдсан магтаал»² хэмээх зохиол юм.

Энэ магтаал нь нийт 58 шүлгээс бүрдсэн жижиг хэмжээний зохиол бөгөөд уг зохиолыг юунд зориулан зохиосон болон хаана бичсэн зэрэг баримт төгсгөлийн үгэнд тодорхой байна.

Харин зохиогч уг магтаалыг хэдүйд зохиосноо тодорхой бичээгүй тул хэдүйд зохиосон болохыг Зонхавагийн намтар зэрэг зарим төвд сурвалжийн мэдээгээр тодруулан үзье.

XIII зууны үеийн Монголын эрдэмтэн Цахар гэвш Лувсанцүлтэм (1740— 1810) 1791 онд зохиосон Зонхавагийн намтарын 5-р бүлэгт « (Зонхова) 42 насны шорой барс жилийн хавар намар хоёр Дагвалха-